



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/150

Улаанбаатар хот

**Сургалтын төрийн сангийн зээлийн  
санхүүжилтээр гадаадад суралцуулах,  
тушаалд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны “Журам батлах тухай” 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторонтурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам” –ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2016 оны А/279 тоот тушаалын Доржсүрэнгийн Ганчулуунд холбогдох хэсгийн АНУ-ын “Калифорни мужийн их сургууль” гэснийг Австрали Улсын “Грифийн их сургууль” гэж, 2014 оны А/214 тоот тушаалын Болдын Даваажавд холбогдох хэсгийн “2 жил гэснийг 3 жил” гэж, Ганбаатарын Уянгад холбогдох хэсгийн “2 жил гэснийг 3 жил” гэж, 2014 оны А/220 тоот тушаалын Хишигдэмбэрэлийн Хуланд холбогдох хэсгийг “2 жил гэснийг 3 жил” гэж, 2014 оны А/398 тоот тушаалын Эрдэнийн Номинд холбогдох хэсгийг “2 жил гэснийг 4 жил” гэж, 2015 оны А/19 тоот тушаалын Дорждагвын овогтой Мөнхзаяад холбогдох хэсгийг АНУ-ын “GALLAUDET-ийн их сургууль” гэснийг “Колумбия Коллеж”, “2 жил гэснийг 3 жил” гэж өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Э.Энх-Амгалан/-т тус тус даалгасгай.

  
Ж.БАТСУУРЬ

